



МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН  
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 08 сарын 09 өдөр

Дугаар 171

Улаанбаатар хот

Бүтэц зохион байгуулалт, орон тоо,  
дүрмийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4, Иргэний нисэхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7.1.12. дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нислэг, техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны дүрмийг нэгдүгээр хавсралтаар, тус албаны зохион байгуулалтын бүтцийг хоёрдугаар хавсралтаар баталж, орон тооны дээд хязгаарыг 10 байхаар тогтоосугай.
2. Нислэг, техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны зохион байгуулалтын бүтэц, батлагдсан орон тоонд нийцүүлэн жил бүрийн төсвийг батлуулж, үйл ажиллагаагаа зохион байгуулж ажиллахыг Нислэг, техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба /Ж.Цолмон/-нд үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Б.Махбал), Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Т.Гомбосүрэн)-т тус тус даалгасугай.
4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Зам, тээврийн сайдын "Бүтэц, зохион байгуулалт, орон тоо, дүрмийг шинэчлэн батлах тухай" 2015 оны 08 сарын 03-ны өдрийн 213 дугаар тушаал, Зам, тээврийн сайдын "Бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн батлах тухай" 2015 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 340 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САИД

Ж.БАТ-ЭРДЭНЭ



080436